



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 34

Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ